



**ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ,  
АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ,  
ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН  
ДАРГЫН ТУШААЛ**

2014 оны 07 сарын 10 өдөр

Дугаар A/27.

Улаанбаатар хот

Ус хангамжийн үйлчилгээний суурь  
хураамж тооцох заавар батлах тухай

Хот, суурины ус хангамж ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 10.1.1 дэх заалт, ХСҮХАТ-ын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2014 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ нь:

1. Ус хангамжийн үйлчилгээний суурь хураамж тооцох зааврыг хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Ус хангамжийн үйлчилгээний суурь хураамжийг зааврын дагуу тооцож, мөрдүүлэн ажиллахыг ус хангамж, ариутгах татуургын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.
3. Энэхүү зааврын хэрэгжилтийг хянаж, үр дүнг тооцон ажиллахыг тус Зохицуулах зөвлөлийн Үнэ тарифын алба /Ж.Гэрэлчулуун/-нд үүрэг болгосугай.
4. Ус хангамжийн үйлчилгээний суурь хураамж тооцох зааврыг шинэчлэн баталсантай холбогдуулан Зохицуулах зөвлөлийн 2013 оны 7 дугаар сарын 10 ны өдрийн A/16 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА

Ч. ЭРДЭНЭЧИМЭГ



Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн даргын 2014 оны 07 дугаар сарын 10-ний өдрийн 11 дугаар тушаалын хавсралт

УХА0503 3311547

## УС ХАНГАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СУУРЬ ХУРААМЖ ТООЦОХ ЗААВАР

1. Энэхүү зааврыг ус хангамж, ариутгах татуургын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ус хангамжийн үйлчилгээний суурь хураамж мөрдөхөд удирдлага болгоно.

2. Суурь хураамж гэж төвлөрсөн шугамд холбогдсон хэрэглэгчдэд унд, ахуйн стандартын шаардлага хангасан усыг 24 цаг бэлэн байлгасны төлбөрийг хэлнэ.

3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь төвлөрсөн ус хангамж, ариутгах татуургын сүлжээнд холбогдсон хэрэглэгчдэд тухайн сард үйлчилгээний чанарыг ханган, ус хангамжийг тасралтгүй хүргэсний үндсэн дээр суурь хураамжийн төлбөрийг тооцно.

4. Хэрэглэгчийн ус хангамжийн үйлчилгээний суурь хураамжийг тооцохдоо:

- Зохицуулах зөвлөлийн 2014 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн 23 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын тайлбарт “тоолуур суурилагдсан шугамын голч” гэснийг тоолуурын голч гэж үзнэ.
- Ус хангамжийн үйлчилгээний суурь хураамжийг хангагч, хэрэглэгчийн тооцоо хийж буй хүйтэн усны оруулгын шугам тус бүрээр тооцно.
- Төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон хүн амын ус хангамжийн үйлчилгээний суурь хураамжийг 1 айлын орон сууцанд хэдэн айл амьдарч байгаагаас үл хамааран 1 айл өрхөөр, харин 1 өрх хэдэн айлын орон сууцанд амьдарч байгаагаас хамаарахгүйгээр сууц тус бүрээр тооцно.
- Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагад ус хангамжийн үйлчилгээний суурь хураамжийг тооцохдоо:
  - Тоолуур суурилагдсан шугам (тоолуур)-ын голчоор
  - Тоолуургүй тохиолдолд хэрэглэгчийн узельд орсон оролтын шугамын голчоор
  - Тоолуур гэмтсэн, зөрчилтэй тохиолдолд хэрэглэгчийн бууруутай нь тогтоогдвол оруулгын үндсэн шугамын голчоор, хэрэглэгчээс үл хамаарсан бол тоолуур суурилагдсан шугамын голчоор тус тус тооцно.

5. Суурь хураамжийг тооцохдоо дараах зарчмыг баримтална. Үүнд:
- 5.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч тухайн сард хэрэглэгчийг усаар хангасан хугацаанаас хамааран суурь хураамжийг тооцно.
  - 5.2. Ус тасарсан тохиолдолд ханган нийлүүлэгч байгууллага сарын суурь хураамжийг доорх хүснэгтийн дагуу бууруулан тооцож авна.

Хүснэгт-1

Ус тасарсан өдөр (сараар)	1	2-4	5-7	8-10	11-с дээш
Суурь хураамжийг бууруулан тооцох хувь	0%	25%	50%	75%	100%

- 4.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанаас хамааралгүй бусад байгууллага, иргэдийн буруутай үйл ажиллагааны улмаас болон байгалийн гамшиг, давагдашгүй хүчин зүйлсээс үүдэн гарсан гэнэтийн осол аваарын үед шугам сүлжээ, тоног төхөөрөмжид үүссэн гэмтлийг засварлах хугацаанд нэмэлт арга хэмжээ авч хэрэглэгчийг усаар тасралтгүй хангасан тохиолдолд суурь хураамжийг бүрэн тооцно.
6. Хэрэглэгч нь 6 сараас дээш хугацаагаар үйл ажиллагаагаа зогсоох тохиолдолд ажлын 15 хоногийн өмнө албан бичгээр мэдэгдсэний үндсэн дээр суурь хураамжийн төлбөрөөс чөлөөлөгдөж болно.

**Тухайн сард төлөх суурь хураамжийн төлбөр тооцох жишээ:**

1. Тухайлбал “Х” Компани нь өнгөрсөн сард хийгдсэн засварын ажлаас хамааран ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээгээр хэрэглэгчдийг 7 хоног хангаагүй байна. Сарын суурь хурамжийг тухайн 1 өрхөд тооцохдоо:

**Бодолт:**

Ус тасарсан хоног-7

Ус тасарсан хоногоор тооцох хувь хэмжээ-50 хувь (Хүснэгт 1-ээс харна уу)  
1 айл өрхийн төлөх суурь хурамж=2500-2500x0.5=1250 төгрөг/сар

2. "Z"- ААН нь хүйтэн усны 3, халуун усны 1, нийт 4 оруулгын шугамтай. Хүйтэн усны 50мм-ийн 3 оруулгын шугамтай. Тухайн байгууллага хэрэглээний 2 шугамандаа 20мм, 32мм-ийн голчтой 2 тоолууртай. 50мм-ийн шугам нөөцөнд байдаг.

**Бодолт:**

a. Тоолуур суурилагдсан шугам (тоолуур)-ын голчоор:

20 мм-ийн тоолуурын голчийн суурь хураамж-6000 төгрөг

32мм-ийн тоолуурын голчийн суурь хураамж-13680 төгрөг

Нийт суурь хураамж=6000+13680=19680 төгрөг

b. Тоолуургүй тохиолдолд хэрэглэгчийн узельд орсон оролтын шугамын голчоор (Тоолуурын хэвийн ажиллагаа алдагдсан үед)

Тухайн сард 20мм-ийн тоолууртай шугамд гэмтэл гарсан ашиглаагүй тохиолдолд нөөцөнд байгаа 50мм-ийн шугамыг ашигласан. Мөн 32мм-ийн тоолуураар хэвийн ажиллаж байгаа тохиолдолд:

50 мм-ийн голчтой шугамын суурь хураамж- 32080 төгрөг

32 мм-ийн голчтой шугамын суурь хураамж- 13680 төгрөг

Нийт суурь хураамж=32080+13680=45760 төгрөг